Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 02/4270дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

**НЭГ. Товч танилцуулга**[1]

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Ёс зүйн дэд хороог яамны нийт албан хаагчдын санал асуулгын үр дүнд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/106 дугаар тушаалаар албажуулж, үйл ажиллагаа явуулж байна. Тус дэд хорооны 1 гишүүн өөр байгууллагад шилжин ажиллаж ором гарсан тул нөхөн сонгуулийг бүх албан хаагчдын дунд дахин явуулж хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТНБД-ын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/302 дугаар тушаалаар ГБХНХЯ-ны Ёс зүйн дэд хорооны гишүүнээр баталсан. Тус дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хуралдааны дэгийг батлан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 4 удаа хуралдаж, төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн байж болзошгүй тухай 7 гомдол ирснийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн.

**ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар**

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:

- “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, үндэсний хөтөлбөр” 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар батлагдаж, Ёс зүйн хорооны 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 1/108 тоот албан бичгээр үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг салбар, байгууллагын бодлого, төлөвлөлтөд санхүү, төсвийн эх үүсвэрийн хамт тусган хэрэгжүүлэх чиглэлийг ирүүлсэн тул уг хөтөлбөрийг харьяа байгууллагуудад хүргүүлж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалын яамны цахим хуудсанд байршуулсан.
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалын яамны нийт албан хаагчдад Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүүтай хамтран Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, үндэсний хөтөлбөрийн зорилго, үйлчлэх хүрээ сэдвээр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалын салбарын 112 байгууллагын 498 ёс зүйн дэд хорооны гишүүдэд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, холбогдох бусад хууль тогтоомж, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлийг судлан эрсдэлийг бууруулах, сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх, ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, ёс зүйн асуудлыг шийдвэрлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэрээрүүлэх, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, байгууллагын соёлд төрийн албан хаагчийн оролцоо, хандлагын талаарх суурь мэдлэг олгох сургалтуудыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол улсын Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн багш, дэд профессор А.Алтанзул нартай

---

*[1] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.*

*[2] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.*

хамтран танхим болон цахим хэлбэрийг хослуулан 2025 онд тус тус зохион байгуулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайллын хувьд байгууллагын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад Ёс зүйн хороотой хамтарч ажиллахад туслалцаа үзүүлэх гэх мэт манлайлалтай оролцсон.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

*Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд:*

2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Монгол улсын Ёс зүйн хорооноос баталсан сэдэв, агуулгын хүрээнд суурь мэдлэг ойлголтыг эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалын яамны нийт албан хаагчдад Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүүтай хамтран Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, үндэсний хөтөлбөрийн зорилго, үйлчлэх хүрээ сэдвээр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 112 байгууллагын 498 ёс зүйн дэд хорооны гишүүдэд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, холбогдох бусад хууль тогтоомж, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлийг судлан эрсдэлийг бууруулах, сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх, ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, ёс зүйн асуудлыг шийдвэрлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэрээрүүлэх, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, байгууллагын соёлд төрийн албан хаагчийн оролцоо, хандлагын талаарх суурь мэдлэг олгох сургалтуудыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол улсын Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн багш, дэд профессор А.Алтанзул нартай хамтран танхим болон цахим хэлбэрийг хослуулан 2025 онд тус тус зохион байгуулсан.

2025 оны жилийн эцсийн байдлаар танхим болон цахим сургалтаар 111 салбарын байгууллагын болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалын яамны нийт 589 төрийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, хууль, эрх зүйн мэдээллээр хангаж ажиллав.

*Гомдол, мэдээлэл хүлээн авч дүгнэлт гаргах үйл ажиллагааны хүрээнд:*

- Ёс зүйн дэд хороо нь байгуулагдсанаасаа хойш нийт 4 удаа хуралдаж ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн даргыг сонгох, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хуралдааны дэг батлах, ёс зүйн дэд хорооны гишүүнийг нөхөн сонгох, дэд хороонд ирсэн өргөдөл, гомдлыг гишүүдэд хувиарлах, хэлэлцэж шийдвэрлэх, мэдээлэл авах, дүгнэлт гаргах зэрэг үйл ажиллагааг дүрэм журамд нийцүүлэн зохион байгуулж ажилласан.
- 2025 онд Ёс зүйн дэд хороонд нийт 7 гомдол ирснээс 4 гомдол мэдээллийг төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 14.3.1-т заасны дагуу холбогдох байгууллагуудад шийдвэрлүүлэхээр шилжүүлж, 3 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж гомдол гаргагчид хариу хүргүүлсэн.

| Гарсан үр дүн, ололт амжилт: | Бэрхшээл: |
|---|---|

| | |
|---|---|
| ▪ МУ-ын Ёс зүйн хороо, Удирдлагын академи хамтран зохион байгуулж буй Үндэсний сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтад яамны ёс зүйн дэд хорооны гишүүн хамрагдан сургагч багшийн эрхтэй болсон.<br>▪ Яамны хэмжээнд ёс зүйн дэд хороо нь соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж эхэлсэн. | ▪ Ёс зүйн дэд хороо нь үйл ажиллагаа явуулах тодорхой төсөв, санхүүгийн боломжгүйн улмаас хорооны гишүүд өөрсдөө зардал мөнгийг гаргах;<br>▪ Байгууллагын түвшинд удирдах болон ажилтнуудын хувьд ёс зүйн талаарх мэдлэг, ойлголт сул байгаа нь байгууллагын соёл, албан хаагчдын хандлагад тодорхой хэмжээнд сөрөг нөлөө үзүүлж байна. |
| Санал: | |
| ▪ Яамны болон харьяа байгууллагуудын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай хэрэгжүүлэх зорилгоор үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох дүрэм, журмаар зохицуулах шаардлагатай байна.<br>▪ Төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд болон албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ойлголт, хандлагыг дээшлүүлэх зорилгоор шат дараалсан тогтмол сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, танхим болон цахим хосолсон сургалтын хэлбэрийг ашиглах. | |

**Шалгах хэсэг:**

- ✓ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ✓ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ✓ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Томилох эрх бүхий албан тушаалтан
*/Төрийн нарийн бичгийн дарга/* */Л.Мөнхзул/*

Ёс зүйн дэд хорооны дарга
*/Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга /* */Б.Алимаа/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
*/ТЗУГ-ын ХЭЗХ-ийн ахлах шинжээч/* */Д.Энхзаяа/*

/

Огноо: ..... оны ..... сарын .....

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”

| № | Үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт | | Авбал зохих оноо | Оноо/1/ | Хувийн жин /2/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт /3/ | Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх | | 1 | 1 | 10 |
| 2. | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээ хийсэн эсэх | | 1 | 0 | 0 |
| 3. | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал | Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх | 0.5 | 0.5 | 5 |
| | | | Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал | 0.5 | 0.5 | 5 |
| | | | Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал | 0.5 | 0 | 0 |
| | | | Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал | 0.5 | 0 | 0 |
| **Хэсгийн оноо** | | | | **4** | **2** | **20** |
| 4. | Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх */гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо /* | | 1 | 1 | 10 |
| 5. | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал | | 1 | 1 | 10 |
| 6. | | Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал | | 1 | 1 | 10 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | **3** | **30** |
| 7. | Ёс зүйн дэд хороны үйл ажиллагаа | Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал | | 1 | 1 | 10 |
| 8. | | Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол мэдээллийг шийдвэрлсэн байдал */Гомдол ирээгүй бол 1 оноо авна. Нийт ирүүлсэн өргөдөл гомдлын хувийн жингээр тооцно./* | | 1 | 1 | 10 |
| 9. | | | | | | |
| 10 | | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал | | 1 | 1 | 10 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | **3** | **30** |
| **Үнэлгээний нийт оноо, хувь** | | | | **10** | **8** | **80** |

| | | | |
|---|---|---|---|
| | | | |

## ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ “ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО”-НЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, **Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам** | Төсөв, эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙГ ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| **НЭГ. Ерөнхий үйл ажиллагаа** | | | | | | | |
| 1. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын яамны “Ёс зүйн дэд хороо”-ны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулан, түүний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардал | Төлөвлөгөө /тоо/ | 0 | 1 | 4 дүгээр сар | Ёс зүйн дэд хорооны гишүүд |
| | | | Үйл ажиллагааны тайлан /тоо/ | 0 | 1 | 2026 оны 1 дүгээр сар | Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга |
| | | | Ёс зүйн зөрчлийн мэдээ /тоо/ | 0 | 4 | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 2. | Ёс зүйн дэд хорооны хуралдааны дэгийн төслийг боловсруулж, гишүүдээс санал авч батлуулах | Үйл ажиллагааны зардал | Хуралдааны дэг /тоо/ | 0 | 1 | V сар | Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 3. | Ёс зүйн дэд хорооноос баталсан загварын дагуу Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийн хэвлэмэл хуудас захиалах | Үйл ажиллагааны зардал | Хэвлэмэл хуудас тоо | 0 | 20 | V сар | Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 4. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын яамны цахим хуудсанд Ёс зүйн дэд хорооны мэдээллийг байршуулах, мэдээ, мэдээллийг цаг тухайд шинэчлэх | Үйл ажиллагааны зардал | Мэдээ, мэдээлэл /тоо/ | 0 | 5 | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны гишүүд |
| **Хоёр. Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа** | | | | | | | |

***Төлөвлөгөөг баталсан:***

**Ёс зүй дэд хорооны дарга** ..... **/Б.АЛИМАА/**

*(гарын үсэг)*

.....

*(огноо)*

***Төлөвлөгөө боловсруулсан:***

**Ёс зүйн дэд хорооны**
**нарийн бичгийн дарга** ..... **/Д.ЭНХЗАЯА/**

*(гарын үсэг)*

.....

*(огноо)*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт зохион байгуулах | үйл ажиллагааны зардал | Сургалтад хамрагдсан албан хаагч /тоо/ | 0 | 3 | II, I V улирал | Ёс зүйн дэд хорооны гишүүд |
| 6. | Шинээр ажилд орсон албан хаагчид чиглүүлэх 8 цагийн сургалтыг зохион байгуулахад хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтантай хамтарч ажиллах | үйл ажиллагааны зардал | Сургалтад хамрагдсан албан хаагч /тоо/ | 0 | 10 хувь | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны гишүүд |
| 7. | Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн богино хэмжээний видео бичлэг хийж цахимаар сурталчлах | Үйл ажиллагааны зардал | Цахим мэдээлэл /тоо/ | 0 | 2 | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны гишүүд |
| **Гурав. Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол мэдээлэл** | | | | | | | |
| 8. | Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дад хорооны дарга, гишүүдэд танилцуулах, мэдээллээр хангах | үйл ажиллагааны зардал | Гомдол, мэдээлэл /тоо/ | 0 | 100 хувь | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 9. | Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу шуурхай зохион байгуулах | үйл ажиллагааны зардал | Ёс зүйн дэд хорооны дүгнэлт /тоо/ | 0 | 100 хувь | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны гишүүд |

Таницсан:

Ёс зүйн дэд хорооны гишүүд

В.Түвшинжаргал

Д.Ренчиндорж

Д.Мөнгөнтуул

Ц.Алтанцацрал

О.Цэрэнлхам